



83

БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 4. сарын 18

№ 114

Улаанбаатар
хот

**Сургууль цэцэрлэг нэмж
ажиллуулах тухай**

Зарим албан байгууллага ажилчдынхаа хүүхдэд зориулан цэцэрлэг, байгуулсан, цэцэрлэг яслийн барилга байгууламж шинээр ашиглалтанд орсон болон Зөвлөлтийн талаас шилжүүлж авсан цэцэрлэгийн барилгыг ашиглах болсонтой холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:



1. Хотын дүүргүүдэд шинээр ашиглалтад орсон цэцэрлэгүүдэд 157, 158, 159, 160, Хот тохижуулах трестийн цэцэрлэг, 92-р сургууль гэсэн нэр дугаарыг тус тус олгож хүмүүжих, хүүхдийн тоо, бүлэг, ажиллах цаг, нээх хугацааг хавсралт ёсоор тогтоож ажиллуулахыг Хотын боловсролын газар /н.Чимэддорж/-д даалгасугай.

2. Ашиглалтанд орсон 92-р сургууль, 157, 158, 159, 160 дугаар цэцэрлэгүүдийн төсөв, 92 дугаар сургуулийн засварын хөрөнгийг баталж санхүүжүүлэхийг Санхүүгийн газар /Гонгор/, хүнсний материал болон холбогдох зардлыг нэмж хувиарлахыг дэд дарга /н.Жавзмаа/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Хот тохижуулах трестээс ажилчидынхаа хүүхдийн цэцэрлэгт зориулан зардал гаргахыг зөвшөөрсүгэй.



**УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА**


Л.ЭНЭБИШ

Ч.СУМААХҮҮ

Улаандаатар хотын Ардын Хурлын туйцэтгэх
сэхирвэний *1981.09.14* дугаар тогтоолын
хавсралт

Дугаар	сургууль цэцэрлэгийн		ажиллах цаг	бүлэг	хүүхдийн тоо	Цэцэрлэг байгуулсан албан газрын нэр	нээх хугацаа	Хянахын төсвөөр ажиллах
	1	2						
Октябрь	157	12	12	12	280	Төмөр замын СОТ-3-аас шилжиж ирсэн цэцэрлэгийн барилга	22/III	Улсын төсвөөр
Найрамдал	158	12	12	12	330	XIII хороололд шинээр баригдсан барилга	01/У	Улсын төсвөөр
Найрамдал	159	12	12	3	75	Байгууллагын контор засч цэцэрлэг- ийн зориулалтаар	01/У	Улсын төсвөөр
Сүхбаатар	160	12	12	12	280	У хороололд СОТ-2-оос шилжиж ирсэн барилга	09/IV	Улсын төсвөөр
Шуудсаатар	ХТ трест 10	2			50	Контороо засварлан ажилчинхаа хүүхдэд зориулсан барилга	01/У	Байгууллагын төсвөөр
Найрамдал	92	-	20		640	Цагдаагийн 230-р ангиас шилжсэн барилга	16/IV	Улсын төсвөөр